

Чимээгүй Зоригтон

Амьдралын утгагүйд биш утга өгч амьдрахыг сонгосоор л дуусна.Зүгээр л амжиж амьдармаар байна. Зөвхөн бодол дотроо биш бодит байдалд, төгс биш өөрийгөө хайрлаж, төгс биш бусдыг ч ойлгож, хамтдаа л амжиж амьдармаар байна.

Би амьдралд зүрх сэтгэлээсээ байж чадвал тэнгэрт хүрж чадна гэж итгэдэг. Гэхдээ тийм ч хялбар биш, Бид бүгд үүнийг мэднэ.хорвоо ертөнц нөхөрсөг биш ч , бид үүнийг зүрх сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч урагшилдаг.

Яг л хямдралтай дэлгүүрт ороод үнэтэй ноолууран ороолт авж байна гээд баярлаад гартал, цэвэр ноолуур байгаагүй. Дэлгүүрт байхдаа маш жаргалтай, хөөрөөд л нүдээ баясгаад л. Гэвч гэртэй иртэл бид үнэнийг мэдээд ерөөсөө дэмий зүйлд буруу боломжийг ашиглан, Буруу сонголт хийсэн байдаг. Тэрхэн үедээ л зөв мэт санагддаг. Том ч бай жижиг алдаанд тоомжоргүй хандсаар буруу зуршил суусан байдаг. Чи буруу зүйлээр өөрийнхөө дутууг дүүргэх үед гансардаг уг нь дутуугийн мэдрэмж хэвийн хэмжээндээ байвал хүнд маш их хүчийг өгдөг. “Амьдралаа өөрчилъе, өөртэйгөө ажиллая” гэх мэтээр урам зоригоор цэнэглэгддэг. Нэг үгээр зүйрлүүлж хэлэхэд дутуугийн мэдрэмж бол тухайн хүнд өөрт нь өгөгдсөн ид шид гэж ойлгож болно. Харин хэт ихсээд ирвэл дутуу мэдрэмжээ нөхөхийн тулд буруу шийдвэр, буруу сонголтыг хийж, буруу харилцаануудыг үүсгэж эхэлдэг. Нөгөө талаас хэцүү амьдралыг туулах замдаа бид амьдралтай тэмцэх тэмцлийн

явцад өөрийгөө хамгаалахын тулд “санаа зовомтгой, түгшүүртэй” нэгэн ч болж болно. Гэтэл нь хожим нийгмийн харилцааны явцад өнөөх түгшимтгий байдал нь бусдаас өөр, ангид байснаараа ад шоо болж эхэлдэг. Бид фб дээрх сэтгэл хөдөлгөсөн бичлэг эсхүл кино, клип үзээд өрөвдөж, халаглаж, эмзэглэдэг ч бодит амьдрал дээр байгаа кейс, хэн нэгнийг огт хайхардаггүй нь харамсалтай. Бид бусдын муу муухай, өө сэвийг олж, өөлж, өөрөөсөө дутуу, сул доройг өрөвдөж эго-г тэжээдэг нь тун тоогүй. Дутуугийн мэдрэмжээ буруу нөхнө гэдэг эгог л тэжээж буй нь юм. өөрийгөө үнэлэхгүй байх тусам бусад бүх хүмүүс надаас арчаатай, надаас чадвартай юм шиг хийсвэр мэдрэмж үүсдэг. Чимээгүй зоригтон бол хорвоод дугуйхан доторх хүнээ хайрлаж, маш том тэмцэлийг хийж байдаг. Чи сайн байсан ч муу байсан ч дэлхий эргэдгээрээ л эргэж л байна. Гэхдээ чиний доторх дэлхий мөхвөл туйлын гунигтай яа. Зүгээр л оршоод л. Хүн бол гайхамшигтай бие махдбодь оюун ухааны нэгдэл. хүн бол гайхамшигтай. Нэг л зорих юм бол гайхамшигт зүйлсийг бүтээх чадвартай, хүчтэй зоригтой бас ухаантай. Тиймээс нэг зорилго тавиад, анхаарлаа бүрэн төвлөрүүлээд зүтгэ. Юу ч байсан учрыг нь ол. тоглоомын талбарыг гартаа ав. Тэр үед ид шид чамайг тойрон эргэлдэж, бүхий л тохиргоо нь бүрдэж хорвоо ертөнц хүртэл чамд туслаад эхэлнэ. Сэтгэлийг чинь догдлуулж, дүрэлзүүлдэг тэр зүйлээ ахин хойш тавихгүйгээр ганц ганц алхмаар урагшлаад байгаарай.